



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/Ан

Булган сум

**Үзэсгэлэн худалдаа  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7, 18.2, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.14, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны III/05 дугаар тогтоол Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1, мөн хурлын 2020 III/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Нэг суурин-Нэг брэнд” аяныг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдааг Булган суманд 2024 оны 02 дугаар сарын 02-03- ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Цагаан сар-2024” арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд сум орон нутгийнхаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг бэлтгэл сайтай өргөн хүрээтэй оролцуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Амгалан)-д даалгасугай.

4. Арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 1,664,000 (нэг сая зургаан зуун жаран дөрвөн мянга) төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дугаар сарын 30  
өдрийн 14 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**“Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсэг**

“Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд: - Ц.Бүрэнтуяа (Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга)

- М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

- О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

- Г.Алтанцэцэг (Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)

- П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)

- Сумын Засаг дарга нар

- Н.Пүрэвсайхан (“Политехникийн коллежийн захирал)

- Д.Оюунгэрэл (Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, газар тариалангийн хэлтсийн дарга)

